



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

– “Нэг суралцагч-нэг компьютер, нэг анги-нэг
ухаалаг самбар” арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.2, 2.2.4.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Боловсрол, сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан болон дэвшилтэт технологийг нэвтрүүлж, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан контент, сургалтын сан, платформыг хөгжүүлэх, хүүхэд бүрийг компьютероор хангах, анги, танхим бүрийг ухаалаг самбараар тоноглох зорилгоор “Нэг суралцагч-нэг компьютер, нэг анги-нэг ухаалаг самбар” арга хэмжээг хэрэгжүүлсүгэй.

2.“Нэг суралцагч-нэг компьютер, нэг анги-нэг ухаалаг самбар” арга хэмжээг 2026-2028 онд үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Боловсролын сайд Л.Энх-Амгаланд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоо, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судалж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

3.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан тооцоог үндэслэн хөнгөлөлттэй зээл, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх, зээлийн үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд З.Мэндсайхан, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛЫН САЙД

ШТА1206 9023160394 5498449

Н.УЧРАЛ

Л.ЭНХ-АМГАЛАН